



ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 19 өдөр

Дугаар А/08

Аварга

Өмч хамгаалах байнгын зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.1, 31.4, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 04 дүгээр тогтоол, 2022 оны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын өмч хамгаалах байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Зөвлөлийн дарга	-Сан хариуцсан нягтлан бодогч
Нарийн бичиг	-Иргэдийн төлөөлөгчдийн хурлын мэргэжилтэн
Гишүүд	- Байгаль орчны хяналтын улсын байцаагч - Нийгмийн бодлогын мэргэжилтэн -Тамгын газрын Нягтлан бодогч

2. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг боловсруулж батлуулан, хагас бүтэн жилээр хэрэгжилтийг хангаж ажилласан тайланг танилцуулж ажиллахыг зөвлөлийн дарга, гишүүдэд даалгасугай.

3.Засаг даргын Тамгын газрын хөрөнгөд гарсан өөрчлөлт хөрөнгийн хадгалалт хамгаалалт бүрэн бүтэн байдлыг байнга шалгаж эд хөрөнгийн тооллогоор шилжүүлсэн, худалдсан, актлах хөрөнгийг өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцэн дүгнэлт гаргаж, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 04 дүгээр тогтоол, 2022 оны 04 дүгээр тогтоолуудыг мөрдлөг болгон ажиллахыг өмч хамгаалах байнгын зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА

Д.УРАНГОО

